



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/444.

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжтай холбоотой нэр бүхий иргэдээс гаргасан өргөдлийг шалган, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг дарга)  
Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)  
Б.Болормаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Отгончимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)


2. Өргөдөлтэй холбоотой асуудлыг шалган, дүгнэлт гаргаж 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/421 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

ПЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712010936